



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр
хэрэгжүүлэх Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээний
2026 оны тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 19.3.1, 19.3.2, 19.3.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 78 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.1 дэх хэсэгт тусгагдсан арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хавсралтад тусгагдсан чиглэлийн дагуу үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141260449

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 03
дүгээр сарын 06-ны өдрийн /1/ дугаар
тушаалын хавсралт 0785

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

№	Үндсэн чиглэл	Арга хэмжээ
1	Орчны эрүүл мэнд	Агаарын бохирдол, ус, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ, суурь судалгаа Эрүүл мэндийн байгууллагуудыг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, хүлэмжийн хийн ялгарлыг бага болгох санаачлага, арга хэмжээ (Нүхэн жорлонгүй эрүүл мэндийн байгууллага)
2	Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих мэдээллийн нэгдмэл цахим сан, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл олгох цахим мэдээллийн цонх үүсгэх Нийгмийн эрүүл мэндийн эерэг хандлага төлөвшүүлэх, эрүүл мэндэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээ Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, цэцэрлэг, сургууль арга хэмжээ
3	Сэтгэцийн эрүүл мэнд	Архи, тамхи, мансууруулах бодисын нөлөөллийн эсрэг арга хэмжээ Донтох эмгэгийн оношилгоо, эмчилгээ Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, амиа хорлолт Тандалт судалгаа
4	Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл	Осол гэмтэл, хүчирхийлэл Цусны даралт ихсэлтээс урьдчилан сэргийлэх Илүүдэл жин, таргалалт, зөв хооллолт Түргэн хоол, транс тос, чихэрлэг бүтээгдэхүүн Дасгал хөдөлгөөн, нийтийн биеийн тамир Тамхи, тамхинаас гарах инвервенц
5	Халдварт өвчин	Халдварт өвчин болон хеликобактерийн халдвар бууруулах арга хэмжээ
6	Уламжлалт анагаах ухаан	Уламжлалт анагаах ухааны мэдлэгт суурилсан эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ
7	Эмийн зохистой хэрэглээ	Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах
8	Донор	Хүн амын дунд донорыг сурталчлах, цусны донорын эгнээг өргөжүүлэх